



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 18

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 27,129,850,99 (хорин долоон сая нэг зуун хорин есөн мянга найман зуун тавин төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 3,385,312.01 (гурван сая гурван зуун наян таван мянга гурван зуун арван хоёр) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилга байгууламж, худаг усан санг хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Саруулжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
18 тогтоолын хавсралт

Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгуул амжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалта нд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа / жилээр /	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжих нэгж	биет хэмжээ							
1	Склад	Хөрөнгө хадгалах	м2	50.8	1986.01.01	36	1	1,119,850.99	1,119,850.99	165,904.00	953,946.99
2	Моорог	Цогцос хадгалах	м2	21.6	2023.12.28	1	1	10,000	10,000.0	3,333.32	6,666.68
3	Худаг усан сан	Усны нөөц бүрдүүлдэг байсан	м	110	2006.01.01	1	1	26,000,000	26,000,000.0	23,575,301.66	2,424,698.34
Нийт дүн							3	27,129,850.99	27,129,850.99	23,744,538.98	3,385,312.01